



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/457

Есөнбулаг

Захирамжийн хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59.1.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын түүхэн тэгш ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/214 дүгээр захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулж Бигэр сумын 100 жилийн ойг 2024 оны 07 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулахаар тогтоосугай.

2. Баяр наадмын арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж, гэмт хэрэг зөрчилгүй, ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд хуулийн дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга (Г.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тэгш ойг тогтоосон хугацаанд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, 2024 оны төсөвтөө багтаан зохион байгуулж, хурдан морины уралдааны үеэр унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, даатгалд даатгуулан стандартын шаардлагад нийцсэн хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн өмсүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад хяналт тавьж ажиллахыг баяр наадам зохион байгуулах комисст даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

